



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/420

Булган сум

Нийлүүлэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 173 дугаар “Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 19 дүгээр хуралдааны XIX/08 дугаар “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 8 суманд өвөлжилт, хаваржилтын нөхцөл хүндэрч 544.6 мянган мал буюу нийт мал сүргийн 15.1 хувь хорогдсон тул малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах 3000 (гурван мянга) ширхэг халдвар хамгааллын иж бүрэн хувцас нийлүүлэх нийлүүлэгчээр “Аюур тур” ХХК-тай 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т олгосугай.

2. Бараа нийлүүлэгчтэй холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

3. Гэрээний 17,000,000 (арван долоон сая) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний “Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал”-аас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд), 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324010504